



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 27 өдөр

Дугаар #112

Бэрх хот

Ахмад настанд хүндэтгэл үзүүлж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, “Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дах заалт, “Ахмад настны тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дугаар заалт, Захирагчийн зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн №03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэрх хотын нэгдсэн золголт 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр болохтой холбогдуулан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэхэд 600.000 төгрөгийг зарцуулсугай.

2. Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 600.000 (зургаан зуун мянган) төгрөгийг Захирагчийн нөөц сангаас хууль, дүрэм журмын дагуу гаргаж зарцуулахыг нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧ

Ч.ЭНХЖАВХЛАН

232 601 023